

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-12

<i>1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/</i>	3-12
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 08 дугаар сарын 28-ны
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 45 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Жаргалсайхан;

Чөлөөтэй: Х.Баасанжаргал, Д.Ганмаа, Б.Хэрлэн;

Тасалсан: Ч.Лодойсамбуу.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Аудитын менежер Б.Лхагвацэнд, Д.Энхдалай, Ахлах аудитор У.Оюунхүү, Б.Идэрбалжинням, Д.Нямжаргал, шинжээч Ч.Цацрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Баярбаатар нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 31 минут үргэлжилж, 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
16 цаг 45 минут

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Баярбаатар: Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүддээ оройн мэндийг хүргэе. Байнгын хороод өнөөдөр Засгийн газрын хуралдаан нэлээн оройтож тарсантай холбогдуулаад товлосон цагаасаа жоохон хоцорч эхэлж байгаа тул хүлээлгэсэн бол бас хүлцэл өчье.

Ирц танилцуулъя. Ирвэл зохих 9 гишүүн байгаа. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн албан ёсоор чөлөө авсан. Даваасамбуугийн Ганбаа гишүүн гадаад томилолттой. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн гадаад томилолттой. Бадарчийн Хэрлэн гишүүн чөлөө авсан. Ирсэн гишүүдийг танилцуулбал Баярмагнайн Баярбаатар, Аюушийн Ариунзаяа, Жамбын Батсуурь, Дуламын Бум-Очир, Болдын Жавхлан, Ганбатын Очирбат, Дүгэрийн Рэгдэл, Доржзөвдын Энхтуяа гэсэн гишүүд ирсэн байна. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн хоцорч орж ирэх байх. Ингээд 8 гишүүн ирж, 53,8 хувийн ирц хүрсэн учраас өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хэлэлцэх асуудал танилцуулна. Хэлэлцэх 1 асуудал байгаа.

“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 2024 оны 8 сарын 12-ны өдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийн 2 дахь хэлэлцүүлэг өнөөдөр манай Байнгын хороо дээр

хийгдэнэ. Санал, дүгнэлтээ бол Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ. Ямар нэгэн байдлаар батлах тийм шийдвэрийг бол өнөөдөр манай Байнгын хороо гаргахгүй гэдгийг хэлье. Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2 дахь хэсэгт 2 дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод, нам, эвслийн бүлэг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ төсвийн гүйцэтгэлийн талаар, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг сонсож, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нараас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлантай холбоотой асуулт асууж, үг хэлж, санал, дүгнэлт гаргах гэсэн ийм дэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.3-д Байнгын хороо, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 74.4.2-т заасан санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд өгөх ба тус дэд хороо эдгээр санал, дүгнэлтийг хэлэлцэн нэгтгэн гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн ийм дэг байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Болдын Жавхлан, Сангийн сайд, Ёс зүйн дэгийн байнгын хорооны гишүүн, Дэлэгийн Загджав

Монгол Улсын Ерөнхий аудитор орж ирсэн байна уу. Одоо орж ирж байна. Л.Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн, Ц.Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн болон бусад одоо албан тушаалтнууд хүрэлцэн ирсэн байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Болдын Жавхлан сайдын микрофоныг өгье. 3 номер.

Б.Жавхлан: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 онд 23.3 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,5 их наяд төгрөг. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт зардал 2,2 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 785 тэрбум төгрөгийн ашигтай гарсан ба сүүлийн жилүүдэд төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 3,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 3,5 тэрбум төгрөгийг зарцуулан, улсын төсвөөс 100 хувьд санхүүжүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Баярбаатар: Сангийн сайд илтгэл тавилаа. Сангийн сайдад баярлалаа. Загджав аудитор орж ирээгүй байна уу. Аж үйлдвэржилтийн байнгын хороонд асуултад хариулж байна. Тэгвэл Загджав сайдыг орж иртэл Сангийн сайдаас асуух асуулттай гишүүд байна уу. Асуултаа хэдүүлээ явуулчихъя. Байнгын хорооны гишүүдээс асуулт байна уу. гишүүдээс бол асуулт алга. Миний хувьд ганц нэг асуулт асууна.

Ёс зүй, дэгийн байнгын хороо. Манай Байнгын хорооны хүрээнд чиг үүргийн хүрээнд нь Төрийн албаны зөвлөлийн дэргэд Монгол Улсын Ёс зүйн хороо гэж байдаг. Байнгын хороонд харьяалагдана. Орон тооны гишүүдтэй, орон тооны бус гишүүдтэй. Байнгын хорооноос тус гишүүдийг томилох, чөлөөлөх чиг үүрэг нь байж байгаа. Өнөөдөр Төрийн албаны зөвлөлийн дарга Цэдэвсүрэн дарга ирсэн байна. Ёс зүйн хорооны дарга Амартөгс дарга ирсэн байна. Тэгээд өнөөдөр энэ гүйцэтгэлийн талаар бас нэг тодотгол хэлэхэд бол яах вэ, өнгөрсөн хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх ёстой асуудлыг бид нар дээт

өөрчлөлт оруулж байгаад, манай Байнгын хороо хуралдаж Дэгийн хуульд нэмэлт оруулах төслийг өргөн барьж, өнөөдөр энэ эрх зүйн зохицуулалтыг хийж байж энэ гүйцэтгэл хэлэлцэж байгаа. Тэгээд Сангийн сайд өөрөө манай Байнгын хорооны гишүүн байж байгаа. Би Цэдэвсүрэн даргаас асуух гэж байгаа юм. Төрийн албаны зөвлөлийн төсөв миний ойлгосноор бол 19,5 тэрбум төсвийн ерөнхийлөн захирагчид байгаа гэж үзэж байгаа. Энэ Ёс зүйн хорооны төсөв гээд бас өнгөрсөн жилийн төсөв 1,5 тэрбум гэж ойлгосон. Тэгээд энэ төсөв яг энэ 19,5 дотроо багтаж байна уу, эсвэл ийм тусдаа төсөв байгаад байна уу гэдгийг би Цэдэвсүрэн даргаас асууя. Амартөгс дарга бас дараа нь хариулт өгөөрэй. Ер нь бол энэ Ёс зүйн хороо өөрөө энэ хуулиар олгогдсон эрх, үүргээс нь харахад өөрөө төсвийн ерөнхийлөн захирагч байх хэмжээний тийм зохицуулалт хэрэгтэй юм шиг харагдаад байгаа юм. Тэгээд манай Байнгын хорооны гишүүд ч гэсэн энэ дээр бас цаашдаа анхаарч эрх зүйн зохицуулалтыг нь хийх нь зөв болов уу гэж би харж байгаа. Өнөөдөр энэ Ёс зүйн хороо бол бүх төрийн албаны байгууллагууд дээр дэд хороодтой. Тэгээд бид нар энэ авлига, ашиг сонирхол, хүнд суртлаасаа ангид байя гэдэг чиглэлийг хэрэгжүүлээд Монгол Улсын Засгийн газраас “5ш” ажиллагаа гээд олон зүйл хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлээд явж байгаа. Гэтэл бид нар ёс суртахууны доголдол, ёс зүйн асуудлаа бид нар өндөр түвшинд ярих зайлигүй шаардлага үүсчхээд байгаа гэдгийг бол хаана хаанаа ойлгох ёстой. Тэгэхээр энэ дээр бас тодорхой хариулт өгөхийг би 2 даргаас хүсье.

Л.Цэдэвсүрэн: Байнгын хорооны дарга гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. 2023 оны Төрийн албаны зөвлөлийн төсөв бол 3.8 тэрбум. Яг өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал дээр. Энэ дээр бол Ёс зүйн хорооны төсөв гэж байхгүй. Яагаад гэхээр төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай

хууль бол 2023 оны 5 сард батлагдсан. Энэ үед бол төсөв бол хэлэлцэгдээд дуусчихсан байсан үе. 2024 оны буюу энэ жилийн нийт төсөв бол 6.1 тэрбум. Үүний 4,9 нь Төрийн албаны зөвлөл, 1.2 нь Ёс зүйн хорооны төсөв. Ёс зүйн хорооны төсөв маань бол 1,2 нь ингээд гүйцэтгэл нь хэвийн явж байгаа. Таны хэлээд байгаа 19 тэрбумын төсөв бол байхгүй. Бид нар 2025 оны төсвийн төсөл дээрээ Төрийн албаны хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд бид нарын хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагаануудад шаардагдах төсвийг Сангийн яам болон Засгийн газартайгаа нэлээн ойлголцоод ингээд төсөл зүгээр тавьчхаад байгаа. Энэ маань ямар хэлбэрээр өргөн баригдаж хэлэлцэгдэх нь бол дараагийн асуудал юм байгаа юм. Тэгээд дарга 19 тэрбум гэдэг бол энэ оны төсөв биш. Энэ оны төсөв маань Ёс зүй дээр бол 1,2 тэрбум байгаа.

Б.Баярбаатар: Амартөгс дарга асуултад хариулъя.

Ц.Амартөгс: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 2023 онд батлахдаа Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д тавьсан Төрийн албанд Ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ гэдэг энэ бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд энэ хууль батлагдаад, гол нь Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодыг нийт төрийн байгууллагуудын дэргэд байгуулж ажиллуулна. Ингэхдээ хариуцлага хяналтын механизмыг бүрэн бүрдүүлэх ёстой юм гэдэг ийм концепцын хүрээнд байгуулаад, хуулиа гаргаад ингээд явж байгаа. Хууль батлагдсанаас хойш бол бид төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг бол мөн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд батлуулсан. Эндээ бид саяын сахилга хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх тодорхой зүйл зорь. Зорилтуудыг бол заасан, тусгасан. Мөн Улсын Их Хурлаас энэ Төрийн албан

хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбоотойгоор Засгийн газарт 32 дугаар тогтоолоор бол үүрэг өгсөн. Ингэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультай нийцүүлээд энэ харилцааг зохицуулж байгаа болон эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг нийцүүлж оруулж ирэх ийм үүрэг даалгавар өгсөн байгаа. Гэхдээ энэ бол одоогоор бол өргөн баригдаагүй. Хууль тогтоомжийн асуудал нь эцэслэж боловсруулагдаж, өргөн баригдаагүй байгаа учраас бид Ёс зүйн хороо хэдийгээр байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн хэдий ч зарим тодорхой болгох эрх зүйн зохицуулалтууд үлдээд байгаа юм. Үүнтэй холбоотой нэг зүйл нь бол Ёс зүйн хороо, дэд хороод нь бие дааж ажиллах, үйл ажиллагаагаа явуулах үүндээ нийцсэн төсөв, санхүүгийн байдлыг хангалттай бий болгох гэсэн энэ зүйл байгаа. Улсын төсвөөс энэ Ёс зүйн хороо болон дэд хороодын үйл ажиллагааг санхүүжүүлэхээр хуульд тусгасан. Энэ хороо маань бол 9 гишүүнтэй үйл ажиллагаа.../минут дуусав/

Б.Баярбаатар: Амартөгс даргын микрофоныг үргэлжлүүлээд 1 минут өгчих .

Ц.Амартөгс: Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан мөн Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төлөв байдлын үнэлгээ судалгаа хийж, дүн шинжилгээ хийсэн тайланг Ёс зүй дэгийн байнгын хороонд танилцуулах үүргийг Ёс зүйн Хороонд өгсөн байгаа. Тэгэхээр бид одоо тайлангаа энэ Байнгын хороонд танилцуулах үүрэг чиглэлийн хүрээнд үйл ажиллагаагаа бодлогын зорилтоо хэрэгжүүлж ажиллаж байгаа. Энэ оны үйл ажиллагаагаа 2 дугаар сараас эхлээд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн.

Нийт 4239 байгууллага дээр дэд хороо байгуулагдахаас 1172 байгууллага дээр үйл ажиллагаагаа явуулаад, энэ хууль тогтоомжийн дагуу шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажиллаад эхэлсэн. 300 гаруй өргөдлийг хянан шийдвэрлээд, 141 зөрчилтэй гэсэн дүгнэлтийн дагуу хариуцлага.../минут дуусав/

Б.Баярбаатар: Баярлалаа. Жавхлан сайд. 3 номерын микрофоныг өгөөрэй.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөлийн төсөв бол 2024 онд 7,5 тэрбум төгрөгөөр байгаа. 2025 оны төсвийг бол бид 12,5 тэрбум төгрөгөөр урсгал зардлыг нь бол боловсруулаад явж байгаа. Үүнд бол Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны ажлын алба бол 1,1 тэрбум төгрөг. Ирэх жил бол энэ төсвийг бол 1,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр бол эхний байдлаар тооцоо хийгдээд явж байгаа. Гэхдээ энэ нөгөө тооцооллын шатанд яваа. Яг Засгийн газраас бол эцэслэн өргөн баригдаагүй байна. Сая Амартөгс даргын хэлсэн дээр бас нэмээд хэлэхэд бол Төрийн албаны ёс зүйн тухай хууль бол батлагдсан. Тэгээд энэ хуультай нийцүүлж бусад хуулийн шаардлагатай өөрчлөлтийг оруулж ирэхээр бас үүрэг өгчихсөн байгаа. Одоогоор бол энэ хууль маань орж ирээгүй байгаа. Дээр нь Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 11.1-д Ёс зүйн хороо нь төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллана гэхээд байгаа юм. Тэгэхээр бид нөгөө тусад нь төсвийн ерөнхийлөн захирагч болгож болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ ерөнхийлөн захирагч болохын тулд энэ хуулийн заалтаа бас эргэж харах уу, эсвэл нөгөө энэ хуультай нийцүүлж бусад хуулийг өөрчилнө гэхчихсэн учраас яах вэ гэдэг бас нэг ийм гацаанд орчихоод байгаа. Тэгэхээр Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга та чиглэл өгөх юм бол тэр дагуу бид бас ажиллаад,

цаашидаа 2025, 2026 оны төсөв дээрээс бас ингээд тусад нь бие даасан юу байгаад оруулж ирэх бас боломж байгаа гэж үзэж байна. Баярлалаа.

Б.Баярбаатар: Баярлалаа. Ер нь бол энэ Монгол Улсын Ёс зүйн хороо гэдэг нэршилтэй ийм байгууллага бол байгуулсан. Мэдээж анхандаа бол Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулж дөнгөж шинээр байгуулагдаж байгаа байгууллага учраас нэг байгууллагын дэргэд байгуулагдах нь бол өөрөө зүйн хэрэг. Одоо бид нар цаашилаад түрүүн Амартөгс даргын хэлж байгаагаар 4 мянга гаруй байгууллага дээр дэд хороодтой байх ёстой. Одоогоор бид нар 1 мянга гаруй дээр нь байгуулчихсан явж байна гэж байгаа юм. Тэгээд цаашилаад үргэлжлээд 3 мянга гаруй байгууллага дээр дэд хороод байгуулагдана. Тэгээд энэ шат шатандаа бид нар өөрөө энэ ёс зүй гэдэг зүйлийг, ёс суртахуун гэдэг зүйлийг төлөвшүүлэх ийм зайлиггүй шаардлага нь нийгэмд тулгамдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 2025 оноос эхлээд 2026 онд, 2025 ондоо амждаггүй юм гэхэд 2026 онд бол тусдаа бие даасан байгууллага болгох ийм зорилтыг тавьж ажиллана манай Байнгын хороо. Тэгэхээр энэ дээр бусад байгууллагууд маань анхаараарай гэдгийг бас та бүхэндээ хэлье.

Дээр нь энэ 2025 оны төсөв дээр бас Сангийн сайдтай би Байнгын хороон даргын хувьд уулзаж бас тодорхой саналуудаа хэлсэн байгаа. Тэгэхээр энэ тооцоолол нь гараад боловсруулагдаад ороод ирвэл тодорхой түвшинд бас нэмэгдэнэ гэсэн ийм ойлголттой явж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье.

Ингээд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд тус тус хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Загджав

аудиторын микрофоныг өгөөрэй. 4 номер.

Д.Загджав: Та бүхэндээ энэ оройн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 тайлан нэгтгэсэн. Аудитаар төсвийн эрхлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй бараа, ажил, үйлчилгээг бэлтгэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж шууд худалдан авалт хийсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг 698,4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

Хоёр.Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудиторуд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитор илэрсэн тайлант хугацаанд өр төлбөр үүсгэсэн бараа, материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн, байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлдэг өөрийн орлогыг төсвийн төсөлд тусгаагүй зэрэг

19 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой 4 тэрбум 921,3 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Гурав.Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн. Аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл, анхан шатын баримтын бүрдэлтэй холбоотой 7,2 сая төгрөгийн төслийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Тус Байнгын хороо аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогчгүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх төсвийн зарчмын дагуу жил бүр байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлдэг орлогыг төсвийн төсөлд тусгаагүй, төсвийн төлөвлөгөөнд батлуулаагүй зөрчлийг арилгах. Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Баярбаатар: Ерөнхий аудитор баярлалаа. Сангийн сайдын илтгэлээс бол асуулт асуугаад дуусчихсан байгаа. Ерөнхий аудитор хоцорч орж ирсэн учраас илтгэл нь жоохон хоцорч тавигдаад явсан учраас зөвхөн Ерөнхий аудиторын илтгэлээс асуулт асуух гишүүд байна уу. Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуулт.

А.Ариунзаяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би яах вэ, аудит бол санхүүгийн тайланд яг хяналт шалгалт хийгээд зөрчиж байна уу, үгүй юу гэдэг дээр хяналт тавьдаг гэдгийг ойлгож

байгаа юм. Бусдаар зүгээр энэ хууль хэрэгжилтийг хангаж байна уу, үгүй юу гэдэг дээр аудит маань энэ дээр бас анхаарах боломж байдаг уу. Энэ ер нь л 1 зарчмын асуудал байгаад байгаа байхгүй юу. Би Хөдөлмөрийн сайд байхдаа нөгөө Ахмадын сан буюу тухайн байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадууддаа тухайн байгууллагын цалингийн сангийн 3 хүртэл, 3 хувь биш 3 хүртэл тэр болбол 0,1 хувь ч байж болно тодорхой хэмжээний зардлыг тавьж болно гэсэн энэ ахмад настны хөгжлийн хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч байсан боловч тухайн үедээ аудитын дүгнэлт бол бас хууль зөрчсөн байна гэх маягийн дүгнэлтийг гаргаж байсан санаж байна. Төрийн албаны зөвлөл жишээлбэл төр ч гэсэн өөрөө өмчийн хэлбэр үл хамаараад аж ахуйн нэгж байгууллагууд бүгд өөрийнхөө байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадуудад зориулаад ахмадын сангаа цалингийн 3 хүртэлх хувиар байгуулах ёстой гэсэн энэ асуудалд бас анхаарч хяналт тавих боломж байдаг уу. Цаашидаа төр өөрөө хуулиа хэрэгжүүлэх тал дээр анхаарах ийм хэрэгцээ шаардлага байна уу даа гэж миний зүгээс бол хардаг. Угтаа бол байгууллага бүр өөрийнхөө одоо данснаас гарсан гэдэг юм уу, өөрийнхөө байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадууддаа анхаараад ирэх юм бол томоор харахад бүх ахмад настны одоо хөгжлийн асуудал бас арай өөр түвшинд ирэх боломжтой санагддаг юм. Энэ дээр яагаад ер нь хуулийг хэрэгжүүлэх тал дээр яг энэ санхүүгийн аудит дээр зөрчилтэй гэж тухайн үед гарсан юм бол гэдэг ийм асуулт байна.

2 дахь нь болохоор Ёс зүйн хороо дээр зүгээр яг энэ хуулийн хэрэгжилт гэдэгтэй холбоотойгоор Ёс зүйн хороогоор яг энэ хуулийн хэрэгжилт хангагдаж байна уу, үгүй юу гэдэг дээр анхаарч болдог уу. Яг ёс зүй гэдэг дээр энэ хуулийг хэрэгжүүлж байна уу, үгүй юу гэдэг дээр 1 дүгээрт энэ Ахмад настны хөгжлийн тухай хууль, нөгөө

талдаа Жендерийн хууль жишигээр томилогдох албан тушаалууд дээр эмэгтэйчүүдийг томилох ёстой гэсэн энэ хуулийн квот маань хэрхэн яаж хангагдаж байгаа юм бол. Энийгээ тухайн байгууллагын Ёс зүйн хороогоор бас хэлэлцэх боломж байдаг уу, үгүй юу гэдэг ийм асуултыг асуух гэсэн юм. Баярлалаа.

Б.Баярбаатар: Хэн хариулах вэ. 5 номер. 5 номерын микрофоныг өгөөрэй. Өөрийгөө танилцуулаад, асуултад хариулна шүү.

Ц.Наранчимэг: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтэд санхүүгийн тайлангийн аудитаар бас эрсдэлтэй буюу хуулийн ойлголцлын зөрүүтэй асуудлууд маш их гардаг. Зарим байгууллагууд бол цалингийн сангийнхаа 3 хувиар, зарим байгууллагууд бол цалингийн сангийн хэмнэлтийн 3 хүртэл хувиар ч гэдэг юм уу ийм асуудлууд гардаг байгаа. Манай төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн гэсэн 3 аудитыг хийдэг. Аудит хийх сэдвийг Төсвийн байнгын хорооноос баталж өгөөд, Монгол Улсын Ерөнхий аудиторт тухайн Нийцлийн хуульд нийцлийн аудит хий гэсэн сэдэв батлагдаад ирсэн тохиолдолд бол аудит хийх бүрэн боломжтой.

Б.Баярбаатар: Хариулт болсон уу. Тодруулах уу. 1 минут тодруулна.

А.Ариунзаяа: Тэгэхээр энэ дээр яах вэ, төр өөрөө бас энэ гаргаж байгаа хуулиа мөрддөг байх, хэрэгжилтийг хангадаг байх тал дээр бүх төрийн байгууллагууд бас анхаармаар байна гэдгийг энэ таширамд хэлэх гэсэн юм. Тэгээд үүн дээр ч гэсэн Сангийн яам 2025 оны төсвийг оруулж ирэхдээ бас яг энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах тал дээр нь бас анхаарч өгөөсэй гэсэн ийм хүсэлтэй байна. Баярлалаа.

Б.Баярбаатар: Санал хэлчих шиг боллоо. Загджав Ерөнхий аудитор. 4 номерын микрофон.

Д.Загджав: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Ариунзаяа гишүүн бол маш чухал асуудлыг хөндлөө. Бид бол улсын төсөв, санхүү, нийтийн өмчтэй холбоотой ийм үйл ажиллагааны санхүүжилтийг бүх үйл ажиллагааг нь аудит хийгээд явж байгаа. Зүгээр хуулийн хэрэгжилтэд аудит хийх шаардлага байвал бид хийх бас боломжтой. Энэ дээр нийцлийн аудит хийнэ. Энэ дээр Төсвийн байнгын хорооноос гадна, холбогдох байгууллага, албан тушаалтан гомдол, санал гаргавал энэ дээр бас ийм арга хэмжээ авах боломжтой бөгөөд бас хууль, эрх зүйн орчныг нь бас сайжруулаад, илүү гүнзгий ажиллах боломжийг олгох шаардлагатай юм байна лээ. 2025 оны төсөв дээр та бүхэн бас энэ дээр анхаарч байгаарай. Баярлалаа.

Б.Баярбаатар: Ерөнхий аудитор хариулаа. Баярлалаа. Асуулт асууж дууслаа. Санал хэлэх гишүүд байна уу. Санал хэлэх гишүүн байхгүй байна. Очирбат гишүүн байна уу. Очирбат гишүүн.

Г.Очирбат: Түрүүн Аж үйлдвэрийн байнгын хороо дээр хэлж амжсангүй. Наашаа явчихлаа. Тэгээд бид нар бас энэ аудитын газрын тайлангаа их сайхан харж байгаа. Тэгээд 2022 он, 2023 он энэ Монгол Улсын Засгийн газар гүйцэтгэх засаглал чинь өөрөө ингээд 72 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна гээд Аудитаас дүгнэлт гаргачихсан байгаа.

Тэгээд ер нь энэ цаашидаа бид яаж ажиллах юм бэ. Энэ Аудитын үндэсний газраас гаргаж байгаа зөвлөмж, дүгнэлтүүдийг хэрэгжүүлж ажил болгож авч явах нь чухал байна шүү гэдгийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм. Жавхлан сайд түрүүн байсан уу. Жавхлан сайдаас би түрүүн бас асуулга асуусан.

Асууж байхад бол Монгол Улсын нийт өрийг 36,4 тэрбум доллар гээд 117 их наядын Монгол Улс бол яг одоогийн байдлаар өртэй явж байна. Засгийн газрын хэмжээнд болохоор 7,9 тэрбум доллар гээд 27 орчим их наяд төгрөгийн өртэй явж байна. Тэгээд ер нь цаашидаа Монгол Улсын чинь жилийнх нь нийт эдийн засаг нь 72 их наяд улсаараа 117 их наядын өртэй явж байдаг. Тэгээд бид ингээд Ёс зүй, дэгийн байнгын хорооныхон. Ялангуяа энэ өрнөөс нь эзэлж байгаа хамгийн их өрөнд оруулж байгаа газрууд юу вэ гэхээр төрийн өмчит үйлдвэрийн аж ахуйн нэгжүүд байгаад байдаг. Аудитын газрын гаргасан тайлангаар бол 2023 онд бол төрийн өмчит аж ахуйн нэгжүүд бол 5,6-26 хувийн алдагдалтай ажилласан гээд байгаа юм. Ашигтай биш, алдагдалтай. Тэгээд ер нь бид энийг цаашидаа яах юм бэ. Энэ олон аж ахуйн нэгжүүд ингээд татвар төлөгч нарын мөнгөөр амьдраад байдаг. Тэгээд бид Ёс зүйн байнгын хорооны гишүүд тэгээд энэ дээрээ бас нэлээн жоохон анхаарал хандуулж ажиллахгүй бол болохгүй юм байна гэдгийг харж байна.

2-т гэх юм бол Аудитын үндэсний газраас гаргасан зөвлөмжийг гүйцэтгэх засаглалынхан бол нэлээн тийм урдаа барих, тэргүүлэх зэрэглэл болгож ажил болгож явахгүй бол болохгүй юм байна. Жилийн жилд л ажлаа 60, 70 хувь хийдэг. Тэгээд Монгол Улсыг хөгжсөөд байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн нь өсөөд байна гээд байдаг. Яг ард иргэдийн карманд орж байгаа амьдрал дээшлээд байгаа юм гээд иргэдтэй очоод уулзахаар байхгүй. Тэгэхээр Үндэсний аудитын газрын зөвлөмжийг ажил болгож, гүйцэтгэх засаг бол авч явах нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа шүү.

Тэгээд Үндэсний аудитын газрын бас дарга удирдлагуудад би бас чуулган дээрээс хэлсэн. Та хэд маань энэ алдагдсан боломжоо тооцоорой. Асар их хэмжээний 2013, 2014, 2018 онд тавиад 2024 он хүртэл үргэлжилж байгаа энэ

төсөл хөтөлбөрүүд байна. Энд чинь асар их хэмжээний мөнгө энэ дарга цэрэг нар чинь идэж, ууж байна. Энийг та хэд маань бас ингээд зоригтой байр сууриас хэлж байхгүй бол энэ үйл ажиллагаа чинь цаашиаа ингээд даамжраад байх тусам төрд бугласан идээ бээр чинь улам л буглаад байна шүү. Тэгэхээр энэ дээр бас энэ алдагдсан боломжийг яг тоон утгаар нь илэрхийллээр нь гаргаж ирж бас Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангавал их сайн байна шүү гэж та бүхэндээ хэлэх гэсэн юм.

Тэгээд Их Хурлын үе үеийн гишүүд бас энэ Үндэсний Аудитын газрынхныг хэлдэг. Энэ Их Хурлын гишүүдийн нүд чих болсон байгууллага. Тэгэхээр ажлаа улам сайжруулаарай. Ингээд залуу гишүүд ялангуяа энэ Ардчилсан намын чөлөөт эдийн засгийг дэмждэг гишүүд ихэнхээр орж ирсэн. Та хэдийн ажлыг дэмжиж ажиллана. Энэ төрд болохгүй байгаа бүх бугширсан идээ бээрийг бол хамтдаа бас энэ шахаад, шүүмжлээд явахад бол бэлэн байгаа.

Энэ аудитын газраас гаргасан тайлантай нэг бүрчлэн танилцаж байгаа. Ялангуяа төрийн өмчтэй холбоотой ажлуудыг бол нэлээн шахааж шаардаж араас нь хөөцөлдөж ажиллах болно гэдгээ илэрхийлье. Баярлалаа та бүхэнд.

Б.Баярбаатар: Очирбат гишүүн санал хэллээ. Тэгээд сая Очирбат гишүүнтэй санал нэг байна. Ер нь бол Ёс зүй, дэгийн байнгын хороо, ёс зүй, ёс суртахуун гэдэг тал дээр бол нэлээн шахалт үзүүлж ажиллана. Бид нар энэ ёс суртахуун, ёс зүй гэхээрээ хувь хүмүүсийн хоорондын харилцаа, хувь хүн өөрөө их ёс суртахуунтай байх гэж ойлгоод байдаг юм. Үгүй л дээ. Хөрөнгө, санхүү зарцуулах чинь өөрөө ёс суртахууны нэг хэлбэр байхгүй юу. Ёс зүйн нэг хэлбэр байхгүй юу. Дотроо маш олон төрлийн байдаг.

Тэгэхээрээ энэ мөрийн хөтөлбөрт тусчихсан байгаа Засгийн газрын үйл

ажиллагааны. Энэ индексийг гаргана гээд бид нар. Тэгэхээр олон улсын туршилагад нийцүүлсэн энэ индексийг гаргаж бүх шатны төрийн байгууллагууд мөрдүүлэх ийм чиглэлийг манай Байнгын хорооноос яваандаа хүргүүлнэ. Хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг төрийн албан хаагч, төрийн байгууллагуудад даалгана. Хяналт тавьж ажиллах нь Монгол Улсын Ёс зүйн хороо хяналт тавьж ажиллана. Хуулийн хариуцлага хүлээнэ зөрчсөн тохиолдолд. Тэгээд их тодорхой зажиллана гэдгийг бол хэлье.

Ингээд санал хэлж дууслаа. Манайхаас Төсвийн байнгын хороонд байдаг гишүүн чинь хэн билээ. Төсвийн байнгын хороонд гишүүн байна уу манайхаас. Тэгвэл шууд хүн хүн томилъё доо.

“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна.

“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны Санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүд болон Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны дарга, Ерөнхий аудитор, бусад албан хаагчдадаа баярлалаа. Хурал дууслаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

17.16 цаг.